



## МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2021 ОНЫ ЭХНИЙ 2 САРЫН ГҮЙЦЭТГЭЛ

Монгол Улсын Их Хурлын <http://parliament.mn/c/pwyo> цахим хаягаар, дараах QR кодыг ашиглан бусад танилцуулга, мэдээтэй танилцана уу.



УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН  
ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

**Н**эгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл: 112.8 тэрбум төгрөгийн алдагдалтай байна. Тайлант хугацаан дахь нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеэс 7.2 тэрбум төгрөгөөр, төлөвлөсөн дүнгээс 660.4 тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

**Т**өсвийн орлого: 2021 оны 2 дугаар сарын гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 1,627.6 тэрбум төгрөг болж, **орлогын төлөвлөгөө 22.8 тэрбум төгрөгөөр дутуу биелж, өмнөх оны мөн үеэс 258.3 тэрбум төгрөг буюу 18.9 хувиар буурсан** байна.

- Төлөвлөгөөтэй харьцуулахад нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөө тайлант хугацаанд 1.4 хувиар дутуу биелж, 98.6 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.
- Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого төлөвлөснөөс 22.8 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрөхөд татварын орлого 0.1 хувь буюу 1.8 тэрбум төгрөгөөр, татварын бус орлого 12.2 хувь буюу 21.0 тэрбум төгрөгөөр тус тус дутуу биелсэн нь нөлөөлжээ.
- Тайлант хугацаанд **орлогын албан татвар болон нэмэгдсэн өргтийн албан татвар давж биелсэн** бол бусад төрлийн татварын орлого 3.8-47.3 хувиар төлөвлөснөөс дутуу гүйцэтгэлтэй гарчээ.
- **Татварын бус орлогын төлөвлөгөө** 2021 оны эхний 2 сарын гүйцэтгэлээр **87.8 хувийн биелэлттэй гарч**, 21.0 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөн нь хувьцааны ногдол ашиг болон газрын тосны орлогоос бусад төрлийн татварын бус орлогууд дутуу төвлөрсөнтэй холбоотой байна.

**Т**өсвийн нийт зарлага: Нэгдсэн төсвийн нийт зарлага 2021 оны эхний 2 сарын гүйцэтгэлээр 1,740.3 тэрбум төгрөг болж, **683.2 тэрбум төгрөгийн дутуу зарцуулалттай буюу 71.8 хувийн гүйцэтгэлтэй гарчээ**.

- Нэгдсэн төсвийн нийт зарлагын гүйцэтгэлийг тайлант хугацааны төлөвлөгөөтэй харьцуулахад 28.2 хувиар дутуу зарцуулагдсан ч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 16.9 хувиар буюу 251.1 тэрбум төгрөгөөр ессөн байна.
- Зээлийн үйлчилгээний төлбөр өнгөрсөн оны мөн үеэс **43.0 тэрбум төгрөгөөр буюу 50.2 хувиар буурсан** бол тайлант хугацааны төлөвлөсөн дүнгээс 53.8 тэрбум төгрөгөөр буюу 55.8 хувийн дутуу гүйцэтгэлтэй гарсан байна.

**У**лсын төсвийн хөрөнгө оруулалт: 2021 оны эхний 2 сарын гүйцэтгэлээр 302.7 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс 85.2 тэрбум төгрөгийг зарцуулж 28.2 хувийн гүйцэтгэлтэй байна.

--00--

# МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2021 ОНЫ ЭХНИЙ 2 САРЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА


Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 112.8 тэрбум төгрөгийн алдагдалтай байна.

## 1. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусlamжийн дүн 2021 оны эхний 2 сарын гүйцэтгэлээр 1,627.6 тэрбум төгрөг, нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 1,740.3 тэрбум төгрөг болж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 112.8 тэрбум төгрөгийн алдагдалтай гарчээ.

Тайлант хугацаан дахь нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеэс 7.2 тэрбум төгрөгөөр, төлөвлөсөн дунгээс 660.4 тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

**График 1.** Нэгдсэн төсвийн гүйцэтгэл /тэрбум төгрөгөөр/



2021 оны эхний 2 сарын гүйцэтгэлээр нийт тэнцвэржүүлсэн улсын төсвийн орлого 39.2 тэрбум, орон нутгийн төсвийн орлого 42.5 тэрбум, нийгмийн даатгалын сангийн төсвийн орлого 1.9 тэрбум, эрүүл мэндийн даатгалын сангийн тэнцвэржүүлсэн орлого 19.1 тэрбум төгрөгөөр тус тус дутуу төвлөрсөн байна.

Тайлант хугацаанд нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого өнгөрсөн оны мөн үеэс 18.9 хувь буюу 258.3 тэрбум төгрөгөөр, төсвийн нийт зарлага 16.9 хувь буюу 251.1 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, төсвийн орлогын өсөлт зарлагын өсөлтөөс 2.0 пунктээр их гарсан нь нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7.2 тэрбум төгрөгөөр буурахад нөлөөлжээ.

**Хүснэгт 1.** Нэгдсэн төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр

Тэрбум төгрөгөөр

Алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр	00-ны мөн үед	2021 оны эхний 2 сарын гүйцэтгэл			
		Төл.	Гүйц.	Хувь	Зөрүү
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-96.8	626.3	51.2	8.2	-575.1
Засгийн газрын бонд	-36.5	0.0	0.0	0.0	0.0
Засгийн газрын зээл	253.2	145.9	61.4	42.1	-84.5
Ирээдүйн өв сангийн шилжүүлэг	0.0	0.0	0.0	0.0	0.0
Тогтвортжуулалтын сангийн хуримтлагдсан үлдэгдэл	0.0	0.0	0.0	0.0	0.0
Өмч хувьчлал	0.0	1.1	0.2	17.0	-0.9
<b>НИЙТ ДҮН</b>	<b>120.0</b>	<b>773.2</b>	<b>112.8</b>	<b>14.6</b>	<b>-660.4</b>

Эх сурвалж: Сангийн яам

2021 оны эхний 2 сарын гүйцэтгэлээр гадаад төслийн зээлийн үндсэн төлбөрт 88.8 тэрбум төгрөг төлсөн бол 150.3 тэрбум төгрөгийн гадаад төслийн зээл шинээр авчээ. Засгийн газар урт болон богино хугацаат дотоод бонд шинээр гаргаагүй байна.

**Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 1,627.6 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 18.9 хувь буюу 258.3 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн бол тайланы хугацаанд орлогын төлөвлөгөөг 1.4 хувь буюу 22.8 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн байна.**

## 2. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого

**Н**ийт тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөөний биелэлтийг төсвийн шатлал бүрээр авч үзвэл Улсын төсөв 3.3 хувь буюу 39.2 тэрбум төгрөгөөр, Орон нутгийн төсөв 8.0 хувь буюу 42.5 тэрбум төгрөгөөр, Нийгмийн даатгалын сангийн төсөв 0.4 хувь буюу 1.9 тэрбум төгрөгөөр, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв 11.8 хувь буюу 19.1 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөснөөс дутуу төвлөрсөн байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад орон нутгийн төсвийн орлого 1.8 хувь буюу 8.8 тэрбум төгрөгөөр буурсан бол улсын төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 26.3 хувь буюу 236.6 тэрбум, нийгмийн даатгалын сангийн орлого 12.2 хувь буюу 48.5 тэрбум, эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 2.3 дахин буюу 81.1 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

**Хүснэгт 2.** Нэгдсэн төсвийн орлогын 2021 оны эхний 2 сарын гүйцэтгэл, төсвийн шатлалаар


Тэрбум төгрөгөөр

Ангилал	Улсын төсөв		Орон нутгийн төсөв		НДС		ЭМДС	
	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1,293.6	1,229.3	530.4	487.9	447.8	446.0	162.4	143.3
ИРЭЭДҮЙН ӨВ САН	96.8	42.9	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	21.2	50.1	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1,175.5	1,136.3	530.4	487.9	447.8	446.0	162.4	143.3
Татварын орлого	969.9	1,016.5	223.5	186.1	267.6	265.9	162.4	143.3
Орлогын албан татвар	287.0	338.2	156.3	131.7	0.0	0.0	0.0	0.0
Нийгмийн даатгалын орлого	0.0	0.0	0.0	0.0	267.6	265.9	162.4	143.3
Хөрөнгийн албан татвар	0.0	0.0	24.5	12.9	0.0	0.0	0.0	0.0
Нэмэгдсэн өртгийн албан татвар	336.8	374.5	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Онцгой албан татвар	138.0	122.4	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Тусгай зориулалтын орлого	2.7	2.3	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Гадаад үйл ажиллагааны орлого	132.9	118.5	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Бусад татвар, төлбөр, хураамж	72.6	60.6	42.8	41.5	0.0	0.0	0.0	0.0
Татварын бус орлого	205.6	119.8	306.9	301.8	180.2	180.0	0.0	0.0
Нийтлэг татварын бус орлого	113.7	106.8	32.9	32.1	0.0	0.0	0.0	0.0
Хөрөнгийн орлого	0.0	0.0	0.2	0.2	0.0	0.0	0.0	0.0
Тусlamжийн орлого	27.8	13.0	1.7	0.7	180.2	180.0	0.0	0.0
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	64.1	0.0	272.1	268.7	0.0	0.0	0.0	0.0

Эх сурвалж: Сангийн яам

**График 2.** Нэгдсэн төсвийн орлогын бүтэц /хувиар/

Татварын орлого  
90.7%



Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлогын 90.7 хувийг татварын орлого, 9.3 хувийг татварын бус орлого эзэлж байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2021 оны эхний 2 сарын гүйцэтгэл

“


**Татварын орлого 1,476.9 тэрбум төгрөг болж, орлогын төлөвлөгөө 0.1 хувь дуюу 1.8 тэрбум төгрөгөөр дутчуу төвлөрчээ.**

”

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад татварын орлого 17.7 хувь буюу 221.7 тэрбум төгрөгөөр, татварын бус орлого 32.1 хувь буюу 36.6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Татварын орлогын 31.8 хувийг орлогын албан татвар, 18.6 хувийг нийгмийн даатгалын орлого, 0.9 хувийг хөрөнгийн албан татвар, 25.4 хувийг нэмэгдсэн өртгийн албан татвар, 8.3 хувийг онцгой албан татвар, 0.2 хувийг тусгай зориулалтын орлого, 8.0 хувийг гадаад үйл ажиллагааны орлого, 6.9 хувийг бусад татвар, төлбөр, хураамжийн орлого бүрдүүлж байна.

**График 3.** Татварын орлого /Тэрбум төгрөгөөр/



Эх сурвалж: Сангийн яам

Тайлант хугацаанд татварын орлого 1.8 тэрбум төгрөгөөр тасалдсан нь орлогын албан татвар болон нэмэгдсэн өртгийн албан татвалаас бусад төрлийн татварын орлогын төлөвлөгөө дутуу биелсэнтэй холбоотой байна. Төлөвлөгөөтэй харьцуулахад нийгмийн даатгалын орлого 3.8 хувь /10.9 тэрбум төгрөг/, хөрөнгийн албан татвар 47.3 хувь /11.6 тэрбум төгрөг/, онцгой албан татвар 11.4 хувь /15.7 тэрбум төгрөг/, тусгай зориулалтын орлого 13.6 хувь /0.4 тэрбум төгрөг/, гадаад үйл ажиллагааны орлого 10.8 хувь /14.4 тэрбум төгрөг/, бусад татвар, төлбөр хураамж 11.5 хувь /13.3 тэрбум төгрөг/-иар тус тус төлөвлөснөөс дутуу биелэлттэй гарсан бол орлогын албан татвар 6.0 хувь /26.7 тэрбум төгрөг/, нэмэгдсэн өртгийн албан татвар 11.2 хувь /37.7 тэрбум төгрөг/-иар тус тус төлөвлөгөөг давуулан биелүүлсэн байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2021 оны эхний 2 сарын гүйцэтгэлээр татварын орлого 221.7 тэрбум төгрөг буюу 17.7 хувиар нэмэгдэхэд нийгмийн даатгалын орлого 25.1 тэрбум (8.4 хувь), онцгой албан татвар 8.6 тэрбум (6.6 хувь), тусгай зориулалтын орлого 0.2 тэрбум (7.1 хувь), бусад татвар, төлбөр, хураамж 6.4 тэрбум (5.9 хувь) төгрөгөөр буурсан ч орлогын албан татвар 65.4 тэрбум (16.2 хувь), хөрөнгийн албан татвар 0.4 тэрбум (3.3 хувь), нэмэгдсэн өртгийн албан татвар 172.0 тэрбум (84.9 хувь), гадаад үйл ажиллагааны орлого 24.2 тэрбум (25.6 хувь) төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ.


6

Татварын дүс орлого 150.7 тэрбум төгрөгт хүрч онгөрсөн оны мөн уэс 32.1 хувь дуюу 36.6 тэрбум төгрөгөөр өссөн бол төвлөвлөснөөс 21.0 тэрбум төгрөг дуюу 12.2 хувшиар дутшуу төвлөрчээ.

2

Татварын бус орлого дутуу төвлөрөхөд төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого 13.8 сая төгрөгөөр давж биелсэн бол гадаад хандив тусламжийн орлого 13.4 тэрбум төгрөгөөр, нийтлэг татварын бус орлого 7.7 тэрбум төгрөгөөр; түүн дотроо төсөвт байгууллагын өөрийн орлого 7.0 тэрбум төгрөгөөр, хүүгийн орлого 3.8 тэрбум төгрөгөөр, торгуулийн орлого 1.9 тэрбум төгрөгөөр, түрээсийн орлого 0.2 тэрбум төгрөгөөр, навигацийн орлого 9.7 тэрбум, бусад орлого 3.1 тэрбум төгрөгөөр тус тус дутуу төвлөрсөн нь нөлөөлжээ. Харин хувьцааны ногдол ашиг 13.4 тэрбум төгрөгөөр, газрын тосны орлого 4.6 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөгөөг давуулан биелүүлжээ.

#### **График 4.** Татварын бус орлогын бүтэц /Хувиар/



Татварын бус орлогын 92.2 хувийг нийтлэг татварын бус орлого, 7.7 хувийг тусlamжийн орлого, 0.1 хувийг хөрөнгийн орлого эзэлж байна. Нийтлэг татварын бус орлогыг бүрдүүлэгч эх үүсвэрүүдийг бүтцийн хувьд авч үзвэл 41.2 хувийг төсөвт байгууллагын өөрийн орлого, 22.2 хувийг газрын тосны орлого, 9.6 хувийг хувьцааны ногдол ашиг, 8.4 хувийг бусад орлого, 7.2 хувийг навигацийн орлого, 6.7 хувийг торгуулийн орлого, 4.4 хувийг хүүгийн орлого, 0.3 хувийг түрээсийн орлого тус тус бүрдүүлж байна.

6

Татварын өрөнхий газар 9.6 хувьшар орлогыг давуулсан төвлөрүүлсэн бол Таяанын өрөнхий газар 12.7 хувьшар төвлөвлөгөөг дутуу биелийгүйлсэн байна.

’

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн дагуу нийт 18 төсвийн ерөнхийлөн захирагч улсын төсөвт орлого төвлөрүүлэх үүрэг хүлээндээж 7 нь төлөвлөсөн орлогыг давуулан биелүүлсэн бол үлдсэн 11 нь 2.3 - 100.0 хувиар дутуу төвлөрүүлсэн гүйцэтгэлтэй байна. Татварын ерөнхий газар 9.6 хувиар орлогыг давуулан төвлөрүүлсэн бол Гаалийн ерөнхий газар 12.7 хувиар төлөвлөгөөг дутуу биелүүлсэн байна.

**Хүснэгт 3.** 2021 оны эхний 2 сарын гүйцэтгэлээр улсын төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа байгууллагын төвлөрүүлэх орлого

## Тәрбум төгрөгөөр

Төсвийн ерөнхийлөн захирагч	ӨО-ны мөнгүйн	2021 оны эхний 2 сарын гүйцэтгэл			
		Төл.	Гүйц.	Зөрүү	Хувь
Сангийн сайд	1,036,691.6	1,204,409.8	1,176,531.3	-27,878.6	97.7
Татварын ерөнхий газар	623,103.7	626,894.6	687,317.6	60,423.0	109.6
Үүнээс: Тогтвортжуулалтын санд	4,357.2	21,218.3	50,111.6	28,893.3	236.2
Ирээдүйн өв санд	90,729.7	91,000.8	42,867.9	-48,133.0	47.1
Гаалийн ерөнхий газар	400,994.6	534,465.6	466,351.4	-68,114.2	87.3
Сангийн яам	10,332.8	18,841.3	10,057.5	-8,783.8	53.4
Гадаад тусlamжийн орлогоос санхүүжих	1,532.9	23,502.1	11,556.0	-11,946.0	49.2
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	727.6	706.2	1,248.7	542.5	176.8

<b>Монгол Улсын Их Хурлын дарга</b>	0.0	16.7	0.2	-16.5	1.3
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	0.0	16.7	0.2	-16.5	1.3
<b>Монгол Улсын Ерөнхий сайд</b>	2,392.3	437.7	2,249.7	1,812.0	514.0
Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	304.1	266.7	2,166.2	1,899.5	812.3
Үүнээс: Ирээдүйн өв санд	0.0	0.0	0.0	0.0	0.0
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	2,088.1	171.0	83.5	-87.5	48.8
<b>Монгол Улсын Шадар сайд</b>	2,102.8	1,537.0	2,828.5	1,291.5	184.0
Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	289.9	650.0	340.9	-309.1	52.4
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	1,813.0	887.0	2,487.6	1,600.5	280.4
<b>Хууль зүй, дотоод хөргийн сайд</b>	7,151.8	9,126.7	5,741.5	-3,385.2	62.9
Улсын бүртгэлийн ерөнхий газар	2,214.5	2,833.3	1,503.2	-1,330.1	53.1
Цагдаагийн ерөнхий газар	224.4	833.3	0.0	-833.3	0.0
Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого	1,148.5	1,771.6	1,137.6	-634.0	64.2
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	3,564.5	3,688.4	3,100.6	-587.8	84.1
<b>Гадаад харилцааны сайд</b>	828.1	702.8	48.6	-654.2	6.9
Дипломат төлөөлөгчийн газрууд	676.5	445.8	45.7	-400.1	10.2
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	151.6	257.0	2.9	-254.1	1.1
<b>Зам, тээврийн хөгжлийн сайд</b>	27,446.4	20,193.4	10,615.1	-9,578.3	52.6
Иргэний нисэхийн ерөнхий газар	26,200.0	19,660.5	10,000.0	-9,660.5	50.9
Зам, тээврийн хөгжлийн яам	36.0	32.9	30.0	-2.9	91.3
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	1,210.4	500.0	585.1	85.1	117.0
<b>Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд</b>	26,624.5	31,917.4	37,211.0	5,293.6	116.6
Ашигт малтмал, газрын тосны газар	26,624.5	31,633.2	36,582.5	4,949.2	115.6
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	0.0	284.2	628.5	344.4	221.2
<b>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд</b>	2,846.7	1,871.8	6,246.9	4,375.1	333.7
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	0.0	100.9	0.0	-100.9	0.0
Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого	86.5	133.1	93.1	-39.9	70.0
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	2,760.3	1,637.8	6,153.8	4,516.0	375.5
<b>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд</b>	6,092.5	25,373.1	19,366.0	-6,007.1	76.3
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	6,092.5	25,373.1	19,366.0	-6,007.1	76.3
<b>Эрүүл мэндийн сайд</b>	4,394.3	708.8	248.1	-460.7	35.0
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	4,394.3	708.8	248.1	-460.7	35.0
<b>Байгаль орчин, аялал жуулчлалын сайд</b>	53.5	16.8	635.2	618.3	3,773.3
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	53.5	16.8	635.2	618.3	3773.3
<b>Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга</b>	11.6	1,977.2	355.2	-1,622.0	18.0
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	11.6	1,977.2	355.2	-1,622.0	18.0
<b>Боловсрол, шинжлэх ухааны сайд</b>	181.3	783.1	201.2	-581.9	25.7
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	181.3	783.1	201.2	-581.9	25.7
<b>Барилга, хот байгуулалтын сайд</b>	0.0	284.4	0.0	-284.4	0.0
Газар зохион байгуулалт, геодези, зурагзүйн газар	0.0	264.4	0.0	-264.4	0.0
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	0.0	20.0	0.0	-20.0	0.0
<b>Батлан хамгаалахын сайд</b>	5,340.6	7,767.3	14,302.8	6,535.5	184.1
Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого	1,253.2	960.3	185.5	-774.9	19.3
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	4,087.4	6,807.0	14,117.4	7,310.4	207.4
<b>Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга</b>	21.0	20.0	53.2	33.2	266.1
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	21.0	20.0	53.2	33.2	266.1
<b>Санхүүгийн зохицуулах хороо</b>	164.1	284.9	135.7	-149.2	47.6
Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	164.1	284.9	135.7	-149.2	47.6

Эх сурвалж: Сангийн яам

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахаад нэгдсэн төсвийн нийт зарлага 251.1 тэрбум төгрөг буюу 16.9 хувиар өсч 1,740.3 тэрбум төгрөг зарцуулагдсан байна.

### 3. Нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээл

Тайлант хугацаанд нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлд 2,423.6 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсний 71.8 хувийг зарцуулж 683.2 тэрбум төгрөгийг дутуу зарцуулжээ. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нэгдсэн төсвийн нийт зарлага 251.1 тэрбум төгрөг буюу 16.9 хувиар өсч 1,740.3 тэрбум төгрөг зарцуулагдсан байна.

**Хүснэгт 4.** Нэгдсэн төсвийн зарлагын 2021 оны эхний 2 сарын гүйцэтгэл,  
/төсвийн шатлалаар/

Тэрбум төгрөгөөр

	Улсын төсөв		Орон нутгийн төсөв		НДС		ЭМДС	
	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,803.0	1,441.6	645.7	343.0	438.0	415.7	202.7	125.9
НИЙТ ЗАРЛАГА	1,861.6	1,435.9	631.6	342.5	438.0	415.7	202.7	125.9
УРСГАЛ ЗАРДАЛ	1,545.9	1,246.7	533.4	320.2	438.0	415.7	202.7	125.9
Бараа, ажил, үйлчилгээний зардал	442.2	283.5	418.4	294.3	5.0	3.8	25.3	0.7
Зээлийн үйлчилгээний төлбөр	96.4	42.6	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Татаас	228.9	201.3	36.6	22.0	0.0	0.0	11.5	6.8
Урсгал шилжүүлэг	778.4	719.3	78.3	4.0	433.0	411.9	165.8	118.4
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	315.7	189.2	98.3	22.2	0.0	0.0	0.0	0.0
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-58.6	5.7	14.0	0.5	0.0	0.0	0.0	0.0
НИЙТ ТЭНЦЭЛ	-627.5	-305.3	-115.3	144.9	9.8	30.3	-40.3	17.4

Эх сурвалж: Сангийн яам

Тайлант хугацаанд төлөвлөснөөс Улсын төсвийн зарлага 361.4 тэрбум, орон нутгийн төсвийн зарлага 302.6 тэрбум, нийгмийн даатгалын сангийн зарлага 22.3 тэрбум, эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага 76.8 тэрбум төгрөгөөр тус тус дутуу зарцуулагджээ.

Өмнөх оны мөн үеэс Улсын төсвийн нийт зарлага 270.8 тэрбум, нийгмийн даатгалын сангийн зарлага 37.9 тэрбум, эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага 77.2 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэж зарцуулагдсан бол орон нутгийн төсвийн зарлага 35.6 тэрбум төгрөгөөр буурч зарцуулагдсан үзүүлэлттэй байна.

Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн өнгөрсөн оны мөн үеэс 16.9 хувь буюу 251.1 тэрбум төгрөгөөр өсөхөд урсгал зардал 196.8 тэрбум, хөрөнгийн зардал 39.8 тэрбум, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 14.5 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь нөлөөлжээ.

**Зээлийн үйлчилгээний төлбөр өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 43.0 тэрбум төгрөг буюу 50.2 хувиар буурсан бол тайлант хугацааны төлөвлөсөн дүнгээс 53.8 тэрбум төгрөгөөр буюу 55.8 хувиар дутуу зарцуулалттай гарсан байна.**

**Хүснэгт 5.** Нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн  
гүйцэтгэл /зардлын эдийн засгийн ангиллаар/

Тэрбум төгрөгөөр

	00-ны мөн үе	2021 оны эхний 2 сарын гүйцэтгэл			
		Төл.	Гүйц.	Хувь	Зөрүү
<b>НИЙТ ЗАРЛАГА 6а ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,489.2</b>	<b>2,423.6</b>	<b>1,740.3</b>	<b>71.8</b>	<b>-683.2</b>
НИЙТ ЗАРЛАГА	1,497.5	2,468.1	1,734.1	70.3	-734.0
УРСГАЛ ЗАРДАЛ	1,325.9	2,054.2	1,522.7	74.1	-531.5
<b>БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>596.9</b>	<b>844.4</b>	<b>544.1</b>	<b>64.4</b>	<b>-300.3</b>
Цалин хэлс болон нэмэгдэл урамшил	395.2	427.3	376.6	88.1	-50.7
Үндсэн цалин	290.9	299.0	276.8	92.6	-22.1
Нэмэгдэл	87.6	107.1	84.1	78.5	-23.1
Унаа хоолны хөнгөлөлт	8.9	9.3	8.2	88.3	-1.1
Урамшуулал	3.2	6.1	2.7	45.3	-3.3
Гэрээт ажлын хэлс	4.6	5.8	4.8	81.4	-1.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.0	0.0	0.0	-	0.0
Тэтгэврийн даатгал	0.0	0.0	0.0	-	0.0
Тэтгэмжийн даатгал	0.0	0.0	0.0	-	0.0
ҮОМШӨ-ний даатгал	0.0	0.0	0.0	-	0.0
Ажилгүйдлийн даатгал	0.0	0.0	0.0	-	0.0
Эрүүл мэндийн даатгал	0.0	0.0	0.0	-	0.0
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>58.3</b>	<b>70.2</b>	<b>52.0</b>	<b>74.0</b>	<b>-18.2</b>
Гэрэл, цахилгаан	10.2	11.4	7.5	65.9	-3.9
Түлш, халаалт	41.5	49.1	38.5	78.3	-10.6
Цэвэр, бохир ус	3.4	4.2	2.0	48.3	-2.2
Байрны түрээс	3.2	5.5	4.0	72.1	-1.5
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>20.1</b>	<b>31.1</b>	<b>19.7</b>	<b>63.4</b>	<b>-11.4</b>
Бичиг хэрэг	1.7	2.6	1.4	53.3	-1.2
Тээвэр, шатахуун	8.2	11.4	7.8	68.6	-3.6
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1.8	2.7	1.6	59.1	-1.1
Ном, хэвлэл	0.3	0.6	0.1	20.6	-0.5
Хог хаягдал зайлцуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6.6	11.2	7.4	66.5	-3.7
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1.6	2.7	1.4	52.4	-1.3
<b>Нормативт зардал</b>	<b>24.8</b>	<b>31.3</b>	<b>6.1</b>	<b>0.0</b>	<b>-25.2</b>
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	10.8	9.7	1.6	16.6	-8.1
Хоол, хүнс	10.3	14.4	3.4	23.5	-11.0
Нормын хувцас, зөөлөн эдлэл	3.8	7.1	1.1	15.4	-6.0
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>6.4</b>	<b>16.7</b>	<b>3.9</b>	<b>23.3</b>	<b>-12.8</b>
Багаж, техник, хэрэгсэл	2.5	7.8	1.3	16.5	-6.5
Тавилга	0.5	1.4	0.3	22.2	-1.1
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.3	1.6	0.2	15.1	-1.3
Урсгал засвар	3.1	6.0	2.1	34.6	-3.9
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>3.4</b>	<b>4.6</b>	<b>0.8</b>	<b>16.6</b>	<b>-3.8</b>
Гадаад албан томилолт	1.5	1.1	0.1	6.3	-1.0
Дотоод албан томилолт	1.4	2.6	0.4	17.3	-2.1
Зочин төлөөлөгч хүлээн авах	0.5	0.9	0.2	27.4	-0.7
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>48.3</b>	<b>163.4</b>	<b>55.0</b>	<b>33.7</b>	<b>-108.4</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	43.8	147.7	52.1	35.3	-95.5
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.5	1.5	0.4	27.5	-1.1

Даатгалын үйлчилгээ	2.1	3.9	0.8	20.7	-3.1
Тээврийн хэрэгслийн татвар	0.4	0.3	0.0	8.9	-0.2
Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.0	0.1	0.0	12.5	-0.1
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.7	5.2	0.5	10.0	-4.7
Газрын төлбөр	0.0	0.4	0.0	6.8	-0.4
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0.2	2.8	0.4	12.7	-2.5
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	0.5	1.5	0.7	44.2	-0.9
Бараа үйлчилгээний бусад зардал	40.3	99.8	30.0	30.1	-69.8
Бараа үйлчилгээний бусад зардал	35.9	91.2	27.1	29.8	-64.1
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4.4	8.6	2.9	33.9	-5.7
<b>ХҮҮ</b>	<b>85.7</b>	<b>96.4</b>	<b>42.6</b>	<b>44.2</b>	<b>-53.8</b>
Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	46.6	66.5	42.0	63.1	-24.5
Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	39.0	29.9	0.6	2.1	-29.3
<b>ТАТААС</b>	<b>55.5</b>	<b>96.8</b>	<b>50.0</b>	<b>51.6</b>	<b>-46.9</b>
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	10.0	16.5	10.3	62.7	-6.2
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	45.5	80.3	39.6	49.3	-40.7
<b>ҮРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>587.8</b>	<b>1,016.5</b>	<b>886.0</b>	<b>87.2</b>	<b>-130.5</b>
Засгийн газрын урсгал шилжүүлэг	14.0	150.3	86.6	57.6	-63.7
Засгийн газрын дотоод шилжүүлэг	12.9	148.9	85.7	57.5	-63.3
Засгийн газрын гадаад шилжүүлэг	1.1	1.4	0.9	66.8	-0.5
Бусад урсгал шилжүүлэг	573.8	866.2	799.4	92.3	-66.8
Нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмж	373.7	432.6	411.7	95.2	-20.9
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	140.0	374.3	356.0	95.1	-18.3
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.6	1.1	0.4	41.0	-0.6
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	30.4	22.2	17.2	77.4	-5.0
Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	0.0	0.0	0.0	-	0.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21.3	21.2	8.3	39.3	-12.9
Хөдөө орон нутагт тогтвортой суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	6.5	11.9	4.7	39.2	-7.2
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1.3	2.9	1.0	36.1	-1.8
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>171.6</b>	<b>413.9</b>	<b>211.4</b>	<b>51.1</b>	<b>-202.5</b>
Барилга байгууламж	129.6	243.9	170.6	69.9	-73.4
Их засвар	10.1	23.3	5.2	22.5	-18.1
Тоног төхөөрөмж	4.1	65.9	23.1	35.1	-42.8
Бусад хөрөнгө	26.4	72.2	8.6	12.0	-63.5
Стратегийн нөөц хөрөнгө	1.4	8.5	3.8	44.4	-4.7
<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>-8.3</b>	<b>-44.5</b>	<b>6.3</b>	<b>-14.1</b>	<b>50.8</b>
Эргэж төлөгдөх зээл	-14.7	-84.7	-3.6	4.2	81.1
Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	6.5	40.1	9.8	24.5	-30.3

Эх сурвалж: Сангийн яам

“


**Нэгдсэн төсвийн нийт зарлагад урсгал зардлын эзлэх хувийн жин 87.5 хувьд хүрч, онгөрсөн оны мөн үеэс 1.5 пункттээр буурсан байна.**

”

Нэгдсэн төсвийн нийт зарлагын 1,522.7 тэрбум төгрөг буюу 87.5 хувь нь урсгал зардал бөгөөд нийт урсгал зардлын 58.2 хувийг урсгал шилжүүлэг, 35.7 хувийг бараа, ажил үйлчилгээний зардал, 3.3 хувийг татаас, 2.8 хувийг зээлийн үйлчилгээний төлбөр тус тус эзэлж байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нэгдсэн төсвийн урсгал зардал 196.8 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд: бараа, ажил үйлчилгээний зардал 52.8 тэрбум, зээлийн үйлчилгээний төлбөр 43.0 тэрбум, татаас 5.6 тэрбум төгрөгөөр тус тус буурсан ч урсгал шилжүүлэг 298.2 тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ.

**График 5.** Урсгал зардлын бүтэц  
/Хувиар/



“

**Монгол Улсын 2021 оны төсвийн түхай хуулиар 32 төсвийн ерөнхийлөн захирагчдын төсөв зарцууллах эрхийг баталсан дөгөөд 2021 оны эхийн 2 сарын гүйцэтгэлээр цэсийн төсвийн нийт зарлагын төсөв 361.4 тэрбум төгрөгөөр дутшуу зарцуулагдаж 80.0 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.**

”

Төсвийн ерөнхийлөн захирагчдын нийт зарлагын 40.0 хувийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багц, 16.9 хувийг Боловсрол, шинжлэх ухааны сайдын багц, 16.4 хувийг Сангийн сайдын багц, 6.5 хувийг Эрүүл мэндийн сайдын багц, 5.5 хувийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын багц, 2.5 хувийг Батлан хамгаалахын сайдын багц, үлдэх 12.2 хувийг бусад төсвийн ерөнхийлөн захирагчдын багцын төсвийн зардал эзэлж байна.

**Хүснэгт 6.** Улсын төсвийн нийт зардал, төсвийн ерөнхийлөн захирагчаар

Тэрбум төгрөгөөр

Төсвийн ерөнхийлөн захирагч	2021 оны эхний 2 сарын гүйцэтгэл			
	Төлөв.	Гүйц.	Зөрүү	Хувь
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА	1,435.7	640.0	795.7	44.6
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА	9,363.6	7,242.4	2,121.2	77.3
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД	27,116.6	15,587.3	11,529.3	57.5
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА	9,728.7	5,646.1	4,082.7	58.0
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД	19,105.5	10,896.1	8,209.3	57.0
САНГИЙН САЙД	370,172.1	236,598.6	133,573.5	63.9
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД	43,658.6	35,485.8	8,172.7	81.3
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД	110,179.0	94,407.2	15,771.7	85.7
МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДАРГА	393.9	265.5	128.4	67.4
УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧ	752.6	630.7	122.0	83.8
ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА	9,909.4	7,884.7	2,024.7	79.6
УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР	7,452.7	5,134.8	2,317.8	68.9
ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА	880.3	824.9	55.4	93.7
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР	3,975.6	2,654.8	1,320.8	66.8
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА	1,639.6	1,293.2	346.3	78.9
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА	1,341.4	480.4	861.0	35.8
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА	327.9	215.1	112.8	65.6
ЦАГААТГАХ АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ УЛСЫН КОМИССЫН ДАРГА	1,062.8	1,050.3	12.5	98.8
МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД	47,526.7	20,536.1	26,990.6	43.2
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ДАРГА	4,170.1	269.8	3,900.3	6.5
ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ДАРГА	180.8	166.8	13.9	92.3
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА	3,800.6	2,578.4	1,222.2	67.8
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД	30,886.2	7,633.3	23,252.9	24.7
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД	101,957.6	79,315.1	22,642.5	77.8
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД	15,284.5	13,131.8	2,152.7	85.9
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД	251,724.3	244,341.8	7,382.6	97.1
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД	39,728.8	30,115.8	9,613.1	75.8
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД	1,638.9	1,083.4	555.6	66.1
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХҮЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД	65,619.7	24,490.2	41,129.5	37.3
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	10,591.9	10,080.7	511.2	95.2
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД	603,319.9	576,227.7	27,092.3	95.5
СОЁЛЫН САЙД	8,110.2	4,680.8	3,429.4	57.7
<b>НИЙТ ЗАРДАЛ</b>	<b>1,803,036.2</b>	<b>1,441,589.6</b>	<b>361,446.6</b>	<b>80.0</b>

Эх сурвалж: Сангийн яам

**2021 оны эхний 2 сарын гүйцэтгэлээр 302.7 тэрбум төгрөг зарцуулхааар төлөвлөснөөс 85.2 тэрбум төгрөгийг зарцуулж 28.2 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.**

#### 4. Улсын төсвийн хөрөнгө оруулалт

Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардалд 2021 онд нийт 1,390.9 тэрбум төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөсөн. 2021 оны эхний 2 сарын гүйцэтгэлээр 302.7 тэрбум төгрөг зарцуулхааар төлөвлөснөөс 85.2 тэрбум төгрөгийг зарцуулж 28.2 хувийн гүйцэтгэлтэй байна. 2021 оны төсөвт нийт 24 Төсвийн ерөнхийлөн захирагчид хөрөнгө оруулалтын зардал батлагдсанаас 2021 оны эхний 2 сарын байдлаар 12 төсвийн Ерөнхийлөн захирагчийн санхүүжилт олгогджээ.

#### Хүснэгт 7. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, төсвийн ерөнхийлөн захирагчаар

Тэрбум төгрөгөөр


Хуулийн дугаар	ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ	Төсөвт өртөг	2021 ОН					
			Төсөв	ЭХНИЙ 2 САРЫН ТӨСӨВ	ЭХНИЙ 2 САРЫН САНХҮҮЖИЛТ	ЗӨРҮҮ	ХУВЬ	
I	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА	1,066.6	1,066.6	-	-	0.0	-	
II	МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА	3,570.3	3,570.3	-	-	0.0	-	
III	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД	151,128.8	34,330.4	5,778.5	3,035.9	2,742.6	52.5	
IV	МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД	32,646.3	22,015.1	-	-	0.0	-	
V	МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА	111,547.5	32,963.1	4,933.0	1,326.2	3,606.8	26.9	
VI	БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД	31,998.0	18,045.0	2,450.0	1,070.5	1,379.5	43.7	
VII	БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД	13,050.0	6,150.0	-	-	0.0	-	
VIII	ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД	4,349.4	4,349.4	-	-	0.0	-	
IX	САНГИЙН САЙД	289,936.6	146,968.5	64,000.0	3,624.5	60,375.5	5.7	
X	ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД	69,098.3	29,157.0	50.00	50.00	0.0	100.0	
XI	ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД	73,109.1	26,250.8	350.00	321.73	28.3	91.9	
XII	БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД	417,047.0	186,290.3	54,245.6	12,086.7	42,158.9	22.3	
XIII	БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД	887,783.2	362,200.3	80,321.5	20,718.0	59,603.5	25.8	
XIV	СОЁЛЫН САЙД	548,984.5	102,874.2	4,206.3	1,861.8	2,344.5	44.3	
XV	ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД	659,743.3	235,176.2	77,579.3	37,830.6	39,748.6	48.8	
XVI	УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД	3,696.9	1,727.1	-	-	0.0	-	
XVII	ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД	50,365.4	23,622.4	180.0	180.0	0.0	100.0	
XVIII	ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	153,017.5	39,052.8	8,619.8	3,120.7	5,499.1	36.2	
XIX	ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД	210,685.5	81,534.7	-	-	0.0	-	
XX	АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА	1,150.0	1,150.0	-	-	0.0	-	
XXI	ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ	4,000.0	4,000.0	-	-	0.0	-	
XXII	УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУОР	43,517.8	26,437.0	-	-	0.0	-	
XXIII	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР	1,497.3	1,497.3	-	-	0.0	-	
XXIV	САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА	492.5	492.5	-	-	0.0	-	
	<b>НИЙТ</b>	<b>3,763,481.8</b>	<b>1,390,921.0</b>	<b>302,714.0</b>	<b>85,226.5</b>	<b>217,487.5</b>	<b>28.2</b>	

Эх сурвалж: Сангийн яам

## 5. Нийгмийн даатгалын сан

### НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА

/Тэрбум төгрөгөөр/



### НИЙГМИЙН ДААТГАЛЫН САН

#### ЗАРЛАГА

415.7 ↑ 10.0%

Тэргүүрийн  
даатгалын сан



377.9

Тэргэмжийн  
даатгалын сан



25.0

Үомшөний  
даатгалын сан



5.6

Ажилгүйдлийн  
даатгалын сан



9.1

#### Нийгмийн даатгалын сангийн орлого

447.8

446.0

397.4

438.0

#### Нийгмийн даатгалын сангийн зарлага

415.7

377.9

■ Төлөвлөгөө

■ Гүйцэтгэл (2021 оны 02 дугаар сар)

■ Өмнөх оны мөн үе



-Өөрчлөлт (Өнгөрсөн оны мөн үеэс)

Монгол Улсын 2021 оны эхний 2  
сарын гүйцэтгэл


Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газрын  
Төсвийн хяналт, шинжилгээний хэлтэс

Эх сурвалж: Сангийн яам

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2021 оны эхний 2 сарын гүйцэтгэл

Нийгмийн даатгалын сангийн зарлагад 415.7 тэрбум төгрөгийг зарцуулсан нь өнгөрсөн оны мөн үеэс 37.9 тэрбум төгрөг буюу 10.0 хувиар өссөн байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад тэтгэврийн даатгалын сангийн зарлага 35.8 тэрбум, тэтгэмжийн даатгалын сангийн зарлага 1.3 тэрбум, ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага 0.2 тэрбум төгрөгөөр өссөн бол ҮОМШӨ-ний даатгалын сангийн зарлага 1.3 тэрбум төгрөгөөр буурчээ.


**График 6.** Нийгмийн даатгалын сангийн нийт зарлагын бүтэц /Хувиар/



#### 6. Эрүүл мэндийн даатгалын сан

**“**  
Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө 11.8 хувиар дутуу биелэв.  
**”**


**График 7.** Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого /Тэрбум төгрөгөөр/



Эрүүл мэндийн даатгалын санд 2021 оны эхний 2 сарын гүйцэтгэлээр 143.3 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн нь төсөвлөснөөс 11.8 хувь буюу 19.1 тэрбум төгрөгөөр дутуу биелж, орлогын гүйцэтгэл 88.2 хувтай гарчээ.

**“**  
Эрүүл мэндийн даатгалын сангаас 125.9 тэрбум төгрөгийн зарлага хийгджээ.  
**”**

**График 8.** Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага /Тэрбум төгрөгөөр/



2021 оны эхний 2 сарын гүйцэтгэлээр эрүүл мэндийн даатгалын сангаас 202.7 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс 125.9 тэрбум төгрөгийг зарцуулж, тус сангийн гүйцэтгэл 62.1 хувтай гарчээ. Харин өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад тус сангийн нийт зарлага 77.2 тэрбум төгрөг буюу 58.3 хувиар өссөн байна.

## 7. Орон нутгийн төсөв

2021 оны эхний 2 сарын гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн зарлага 302.6 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдсан байна.

**2021** оны эхний 2 сарын гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн орлого 487.9 тэрбум төгрөгт хүрч төлөвлөсөн дүнгээс 8.0 хувь буюу 42.5 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөн бол орон нутгийн төсвийн нийт зарлага 343.0 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөснөөс 46.9 хувь буюу 302.6 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдаж, **орон нутгийн төсвийн тэнцэл 144.9 тэрбум төгрөгийн ашигтай гарчээ.**

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад орон нутгийн төсвийн орлого 1.8 хувиар буюу 8.8 тэрбум төгрөгөөр, орон нутгийн төсвийн нийт зарлага 9.4 хувь буюу 35.6 тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

Орон нутгийн төсвийн нийт орлогын 44.9 хувийг орон нутгийн төсвийн орлого, 47.7 хувийг тусгай зориулалтын шилжүүлэг, 6.7 хувийг улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг, 0.7 хувийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын шилжүүлэг эзэлж байна. Улсын төсвөөс орон нутгийн төсөвт 32.8 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэг, 232.6 тэрбум төгрөгийн тусгай зориулалтын шилжүүлэг олгохоор төлөвлөсөн нь тус бүр 100.0 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын шилжүүлэгт 6.8 тэрбум төгрөг шилжүүлэхээр төлөвлөснөөс 3.4 тэрбум төгрөгийг шилжүүлсэн нь төлөвлөснөөс 50.1 хувиар буюу 3.4 тэрбум төгрөгөөр дутуу олгогджээ.

**График 9.** Орон нутгийн төсвийн орлогын бүтэц /Хувиар/



**Хүснэгт 8.** Аймгуудад улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг, аймгийн тусгай зориулалтын болон орон нутгийн хөгжлийн сангийн шилжүүлэг

Тэрбум төгрөгөөр

АЙМАГ	САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ			ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН ШИЛЖҮҮЛЭГ			ОН-ИЙН ХӨГЖЛИЙН НЭГДСЭН САНГИЙН ОРЛОГЫН ШИЛЖҮҮЛЭГ		
	Олгох	Олгосон	Хувь	Олгох	Олгосон	Хувь	Олгох	Олгосон	Хувь
Архангай	2,196.2	2,196.2	100.0	7,950.8	7,950.8	100.0	267.6	133.6	49.9
Баян-Өлгий	1,148.1	1,148.1	100.0	9,747.4	9,747.4	100.0	363.8	181.6	49.9
Баянхонгор	3,248.1	3,248.1	100.0	7,489.2	7,489.2	100.0	282.1	140.8	49.9
Булган	731.9	731.9	100.0	5,718.9	5,718.9	100.0	166.8	83.3	49.9
Говь-Алтай	2,582.6	2,582.6	100.0	6,773.7	6,773.7	100.0	240.7	120.1	49.9
Дорноговь	0.0	0.0	0.0	6,777.8	6,777.8	100.0	219.8	109.7	49.9

Дорнод	0.0	0.0	0.0	7,242.0	7,242.0	100.0	277.8	138.7	49.9
Дундговь	2,082.6	2,082.6	100.0	4,337.9	4,337.9	100.0	141.2	70.5	49.9
Завхан	3,318.0	3,318.0	100.0	7,541.4	7,541.4	100.0	242.4	121.0	49.9
Өвөрхангай	3,096.4	3,096.4	100.0	9,052.0	9,052.0	100.0	312.3	155.9	49.9
Өмнөговь	0.0	0.0	0.0	6,229.7	6,229.7	100.0	239.4	119.5	49.9
Сүхбаатар	1,631.6	1,631.6	100.0	5,354.8	5,354.8	100.0	195.5	97.6	49.9
Сэлэнгэ	807.7	807.7	100.0	8,613.9	8,613.9	100.0	264.3	131.9	49.9
Төв	1,538.9	1,538.9	100.0	7,783.9	7,783.9	100.0	235.6	117.6	49.9
Увс	2,663.5	2,663.5	100.0	7,991.9	7,991.9	100.0	296.0	147.7	49.9
Ховд	1,687.6	1,687.6	100.0	7,853.9	7,853.9	100.0	317.5	158.5	49.9
Хөвсгөл	3,510.8	3,510.8	100.0	11,317.1	11,317.1	100.0	408.2	203.8	49.9
Хэнтий	2,316.6	2,316.6	100.0	8,184.2	8,184.2	100.0	226.4	113.0	49.9
Дархан-Уул	0.0	0.0	0.0	6,623.7	6,623.7	100.0	216.4	108.0	49.9
Улаанбаатар	0.0	0.0	0.0	81,475.5	81,475.5	100.0	1,563.8	780.7	49.9
Орхон	0.0	0.0	0.0	7,095.3	7,095.3	100.0	238.4	119.0	49.9
Говьсүмбэр	212.5	212.5	100.0	1,436.9	1,436.9	100.0	39.5	19.7	49.9
<b>ДҮН</b>	<b>32,772.9</b>	<b>32,772.9</b>	<b>100.0</b>	<b>232,591.8</b>	<b>232,591.8</b>	<b>100.0</b>	<b>6,755.5</b>	<b>3,372.5</b>	<b>49.9</b>

Эх сурвалж: Сангийн яам

Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, соёлын үйлчилгээ, эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ, газрын харилцаа, кадастр, хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээ, нийтийн биеийн тамир зэрэг **Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэхэд нийт 232.6 тэрбум төгрөгийн тусгай зориулалтын шилжүүлэг аймгуудад** олгожээ. Харин орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд хуваарилахаар 6.8 тэрбум төгрөг төсөвлөснөөс 49.9 хувь буюу 3.4 тэрбум төгрөгийг шилжүүлсэн байна.

Орон нутгийн орлогыг аймгуудаар харуулбал; Архангай аймаг 131.7 сая, Баянхонгор аймаг 891.8 сая, Булган аймаг 206.6 сая, Говь-Алтай аймаг 155.9 сая, Дорноговь аймаг 2,053.4 сая, Дорнод аймаг 594.3 сая, Дундговь аймаг 1,641.2 сая, Өвөрхангай аймаг 581.4 сая, Сүхбаатар аймаг 1,194.9 сая, Төв аймаг 1,999.8 сая, Ховд аймаг 1,381.0 сая, Хөвсгөл аймаг 157.3 сая, Хэнтий аймаг 6,960.1 сая, Улаанбаатар хот 38,339.3 сая төгрөгөөр тус тус төлөвлөснөөс дутуу төвлөрүүлсэн бол Баян-Өлгий аймаг 51.4 сая, Завхан аймаг 212.2 сая, Өмнөговь аймаг 8,070.6 сая, Сэлэнгэ аймаг 841.8 сая, Увс аймаг 44.9 сая, Дархан-Уул аймаг 883.3 сая, Орхон аймаг 3,444.6 сая, Говьсүмбэр аймаг 234.1 сая төгрөгөөр тус тус төлөвлөгөөг давуулан биелүүлжээ.

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН  
ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС**